



2025 оны IV улирал

ЭРҮҮЛ МЭНДИЙН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ

Орхон аймаг

Нэг.Эх хүүхдийн эрүүл мэнд


Төрөлт

Аймгийн хэмжээнд 2025 оны байдлаар 1923 эх төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 82 төрөлтөөр буюу 1.0 хувиар буурч, төрсөн эхчүүдийн 1804 нь буюу 93.8 хувь нь эмчийн хяналтын үзлэгт 6 ба түүнээс удаа хамрагдсан нь өмнөх оноос 14.6 хувиар өссөн. Нийт төрөлтөд амьгүй төрөлт 9 буюу 0.5 хувь байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1 тохиолдлоор буюу 1.1 хувиар нэмэгдэж, гэрийн төрөлт 3 бүртгэгдэж өнгөрсөн оны мөн үеээс 1 тохиолдлоор нэмэгдсэн байна. Орон нутгаас Орхон аймагт ирж амаржиж буй эхчүүдийн 6.8 хувь нь Булган аймаг, 4.2 хувь нь Улаанбаатар хот 3.0 хувь Сэлэнгэ аймаг, 1.8 хувь нь Хөвсгөл, 1.0 хувь нь Архангай аймгууд эзэлж байна.

Орон нутгаас ирж амаржсан эхчүүд бодит тоо

| | Архангай | Баянхонгор | Булган | Говь-алтай | Дорноговь | Дорнод | Дундговь | Завхан | Өвөрхангай | Өмнөговь | Сүхбаатар | Сэлэнгэ | Төв | Увс | Ховд | Хөвсгөл | Хэнтий | Дархан-уул | Улаанбаатар | Говьсүмбэр | Бүгд | Нийт төрөлтөд |
|------|----------|------------|--------|------------|-----------|--------|----------|--------|------------|----------|-----------|---------|-----|-----|------|---------|--------|------------|-------------|------------|------|---------------|
| 2024 | 27 | | 144 | 1 | 6 | 1 | 3 | 5 | 4 | 6 | 1 | 69 | 7 | 1 | 2 | 32 | 4 | 4 | 87 | 3 | 407 | 20.3 |
| 2025 | 20 | 2 | 131 | 1 | | 3 | 1 | 3 | 2 | 6 | 1 | 57 | 4 | 11 | 1 | 35 | 3 | 7 | 80 | | 368 | 19.2 |

Төрсөн эхчүүд насны ангилал хувиар



Насны хувьд 4.0 хувийг 20 хүртэлх насны төрөлт эзэлж байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 9 тохиолдлоор буюу 0.7 хувиар, 27.4 хувийг 35-аас дээш насны төрөлт эзэлж байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 29 тохиолдлоор буюу 24.6 хувиар тус тус нэмэгдсэн байна. Мэс заслын аргаар төрүүлсэн эх нийт 522 байгаа нь өмнөх онтой харьцуулахад 74 тохиолдлоор буюу 12.4 хувиар буурсан байна.

Төрөлтийн мэдээлэл

| | | Төрсөн эх | Амьд төрсөн нярай | Амьгүй төрсөн нярай |
|-------------------|----------------------|--------------|-------------------|---------------------|
| 2024 оны байдлаар | Орхон аймаг | 2005 | 2017 | 8 |
| | Аймгуудын дүн | 26199 | 26336 | 106 |
| | Улсын дүн | 57319 | 57756 | 290 |
| 2025 оны байдлаар | Орхон аймаг | 1923 | 1936 | 9 |
| | Аймгуудын дүн | 24335 | 24466 | 109 |
| | Улсын дүн | 53716 | 54137 | 252 |

Жирэмсэн, төрөлт, төрсний дараах үеийн хүндрэл

Жирэмсэн, төрөх, төрсний дараах үеийн хүндрэл 2230 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 1152 ногдож байна.

Нийт хүндрэлд:

- Жирэмсэн үеийн хүндрэл 1145 буюу 51.3 хувь
- Төрөх үеийн хүндрэл 892 буюу 40.0 хувь
- Төрсний дараах үеийн хүндрэл 38 буюу 1.7 хувь
- Жирэмсэн, төрөхөөс үл хамаарах өвчний хүндрэл 155 буюу 7.0 хувийг тус тус эзэлж байна.

Жирэмсэн үеийн хүндрэлүүдээс даралт ихсэлт 22.1 хувь, төрөх үеийн хүндрэлээс төрөх хүчний анхдагч болон хоёрдогч сулрал 40.2 хувь, төрсний дараах үеийн хүндрэлээс төрсний дараах үеийн цус алдалт 94.8 хувьтай тэргүүлж байна.

Хүүхдийн эрүүл мэнд

2025 оны байдлаар аймгийн хэмжээнд 1936 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 81 хүүхдээр буюу 4.0 хувиар буурчээ. Төрөлтийн түвшин 1000 хүн амд 18.1 өмнөх оны мөн үеэс 0.9 промиллоор буурсан. Амьд төрсөн хүүхдийн 1000 буюу 51.7 хувь нь хүү, 936 буюу 48.3 хувь нь охин байна. Төрөх үеийн хүйсийн харьцаа 100 охинд ойролцоогоор 93.6 хүү ногдож, амьд төрсөн 1936 хүүхдээс 68 нярай буюу 3.5 хувь нь 2500 гр-аас доош жинтэй төрж, 15 тохиолдол буюу 0.8 хувь нь төрөлхийн хөгжлийн гажигтай төрсөн.

Амьд төрсөн хүүхэд, эхийн тээлтийн хугацаа, хувиар

| Он | Эхийн тээлтийн хугацаа эзлэх хувь | | | | | Төрөлхийн гажигтай төрсөн | 2500 гр-аас доош жинтэй төрсөн |
|--------------------------|-----------------------------------|----------------------|----------------------|----------------------|------------------------|---------------------------|--------------------------------|
| | 22-28 долоо хоногтой | 29-32 долоо хоногтой | 33-36 долоо хоногтой | 37-41 долоо хоногтой | 42 долоо хоногоос дээш | | |
| 2024 оны байдлаар | 0.4 | 0.9 | 5.0 | 93.7 | | 0.9 | 5.2 |
| 2025 оны байдлаар | 0.2 | 0.7 | 4.7 | 94.4 | | 0.8 | 3.5 |

Тав хүртэлх насны хүүхдийн өсөлт хөгжлийн хяналтад давхардсан тоогоор 93389 хүүхэд хамрагдсанаас 0.16 хувь нь туранхай, 0.16 хувь нь тураалтай, 0.26 хувь нь өсөлтийн хоцрогдолтой, А амин дэм уусан 6191, Д амин дэм уусан 81058, олон найрлагат бичил тэжээл хэрэглэсэн 2 хүүхэд байна.


Эхийн эндэгдэл

Аймгийн хэмжээнд 2024, 2025 оны байдлаар эхийн эндэгдэл бүртгэгдээгүй.

Нялхсын эндэгдэл

2025 оны байдлаар нялхсын эндэгдлийн 15 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 7.7 ногдож байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 5 тохиолдлоор буюу 2.2 промиллоор буурч, нялхсын эндэгдлийн 11 буюу 73.3 хувийг нярайн эндэгдэл эзэлж 1000 амьд төрөлтөд 5.7 байна. Нярайн эндэгдлийн нийт 11 тохиолдлын 7 буюу 63.6 хувь нь эрт үеийн эндэгдэл, 4 буюу 36.4 хувийг 7-28 хоногтой нярайн эндэгдэл тус тус эзэлж байна. Нялхсын эндэгдлийг шалтгаанаар авч үзвэл: Перинаталь үеийн эмгэг 60.0 хувь, төрөлхийн хөгжлийн гажиг, төрөлхийн тэмбүү, уушгины хатгаа тус тус 6.7 хувийг, осол гэмтлийн шалтгаант нас баралт 13.3 хувийг эзэлж байна.

1000 амьд төрөлтөд



| | 2024 оны байдлаар | | | 2025 оны байдлаар | | |
|-------------------------|-------------------|-----------------|---------------------|-------------------|-----------------|---------------------|
| | Нялхасын эндэгдэл | Нярайн эндэгдэл | Перинаталь эндэгдэл | Нялхасын эндэгдэл | Нярайн эндэгдэл | Перинаталь эндэгдэл |
| Орхон аймаг | 9.9 | 8.4 | 12.3 | 7.7 | 5.7 | 8.2 |
| Аймгуудын дундаж | 11.9 | | 9.0 | 12.9 | | 9.8 |
| Улсын дундаж | 12.2 | 61.4 | 9.8 | 13.6 | 62.3 | 10.5 |

Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 16 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 8.3 ногдож байгаа нь өнгөрсөн онтой харьцуулахад 5 тохиолдлоор буюу 2.1 промиллоор буурсан байна.

Хоёр.Эмнэлгийн тусламж үйлчилгээ

Амбулаторийн тусламж үйлчилгээ


Аймгийн хэмжээнд 2025 оны байдлаар нийт 803343 эмчийн үзлэг хийгдсэнээс 35.3 хувийг урьдчилан сэргийлэх үзлэг, 41.5 хувийг өвчний учир амбулаторт 7.8 хувийг идэвхитэй хяналтын үзлэг, 15.4 хувийг гэрийн үзлэг тус тус эзэлж байна. Нэг их эмчид ногдох үзлэгийн тоо 1677 байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад урьдчилан сэргийлэх үзлэг 0.2 хувиар, идэвхитэй хяналт 1.1 хувиар өсч, өвчний учир амбулаторийн үзлэг 0.8 хувиар, гэрийн идэвхтэй үзлэг 0.6 хувиар тус тус буурсан байна. Эмчийн үзлэгийг эмнэлгийн төрлөөр харуулбал: 47.7 хувийг өрхийн эмчийн, 25.7 хувийг Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн, 13.8 хувийг хувийн хэвшлийн клиникийн, 5.6 хувийг Эрдэнэт медиал төрөлжсөн эмнэлгийн, 5.5 хувийг Эрдэнэт сувиллын, 1.6 хувийг сумын эмчийн үзлэг эзэлж байна.

| | ЭМБ-ууд | Нийт үзлэг | Үүнээс | | | | | |
|-------------------|--------------------|---------------|---------------------------|---------------------|------------------------|-----------------|-----------------|-------------------|
| | | | Урьдчилан сэргийлэх үзлэг | Нийт үзлэгт эзлэх % | Өвчний учир амбулаторт | Идэвхтэй хяналт | Гэрийн идэвхтэй | Гэрийн дуудлагаар |
| 2024 оны байдлаар | СЭМТ | 10050 | 3361 | 33.4 | 2282 | 778 | 2778 | 851 |
| | БОЭТ | 196723 | 30739 | 15.6 | 149332 | 16615 | 5 | 32 |
| | ӨЭМТ | 380974 | 202587 | 53.2 | 19755 | 33431 | 123114 | 2087 |
| | ХХЭМБ | 117286 | 12647 | 10.8 | 102892 | 1721 | 13 | 13 |
| | ЭТ сувилал | 44278 | 9309 | 21.0 | 33477 | 1434 | 54 | 4 |
| | ЭТ медиал | 57295 | 24098 | 42.1 | 33197 | | | |
| | Аймгийн дүн | 806606 | 282741 | 35.1 | 340935 | 53979 | 125964 | 2987 |
| 2025 оны байдлаар | СЭМТ | 13155 | 4384 | 33.3 | 3676 | 1350 | 2968 | 777 |
| | БОЭТ | 206844 | 37819 | 18.3 | 150565 | 18433 | 24 | 3 |
| | ӨЭМТ | 383183 | 197177 | 51.5 | 26441 | 39390 | 118340 | 1835 |
| | ХХЭМБ | 110912 | 15207 | 13.7 | 93173 | 2531 | 1 | |
| | ЭТ сувилал | 44498 | 9588 | 21.5 | 33912. | 937 | 58 | 3 |
| | ЭТ медиал | 44751 | 19398 | 43.3 | 25353 | | | |
| | Аймгийн дүн | 803343 | 283573 | 35.3 | 333120 | 62641 | 121391 | 2618 |

Эмчийн үзлэг төрлөөр, хувь



Нэг иргэн дунджаар 7.6 удаа эрүүл мэндийн байгууллагад хандаж эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авсан нь өмнөх оны түвшинд байна.



Халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгийн мэдээлэл

Аймгийн хэмжээнд артерийн гипертензи эрт илрүүлэг үзлэгт 18-аас дээш насны нийт 55755 (87.9%) хүн хамрагдсан бөгөөд 39.8 хувь нь эрэгтэй, 60.2 хувь нь эмэгтэй байна. Үр дүнгийн үзүүлэлтээр нийт үзлэгийн 0.86 хувь нь артерийн гипертензи онош батлагдсан байна. Чихрийн шижин өвчний эрт илрүүлэг үзлэгт 35-аас дээш насны нийт 42878 (103.6%) хүн хамрагдсанаас 40.1 хувь нь эрэгтэй, 59.9 хувь нь эмэгтэй байна. Үр дүнгийн үзүүлэлтээр 0.4 хувьд нь чихрийн шижин өвчний онош батлагдсан байна. Элэгний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт 40-65 насны 2224 (119.7%) хүн хамрагдсан.


| | | АРТЕРИЙН ГИПЕРТЕНЗИ ЭРТ ИЛРҮҮЛЭГ | | | ЧИХРИЙН ШИЖИН ХАМ ШИНЖ -2 ЭРТ ИЛРҮҮЛЭГ | | |
|-------------------|------------------|----------------------------------|---------------------------------|--------------------|--|---------------------------------|--------------------|
| | | Хамрагдсан хүний тоо | Оношлогдсон артерийн гипертензи | Хамрагда лтын хувь | Хамрагдсан хүний тоо | Оношлогдсон артерийн гипертензи | Хамрагд алтын хувь |
| 2024 оны байдлаар | Орхон | 49778 | 339 | 98.2 | 45772 | 157 | 90.3 |
| | Улсын дүн | 1466875 | 0.6 | 68.7 | 1176543 | 0.2 | 87.5 |
| 2025 оны байдлаар | Орхон | 55755 | 355 | 87.9 | 42878 | 169 | 103.6 |
| | Улсын дүн | 1561831 | 0.6 | 72.0 | 1196468 | 0.2 | 85.9 |

Умайн хүзүүний эрт илрүүлэг үзлэгт зорилтот насны нийт 3487 эмэгтэй хамрагдаж, хамрагдвал зохих насны эмэгтэйчүүдийн 60.5 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 34.4 хувиар буурч, нийт 2969 шинжилгээнээс 2681 буюу 90.3 хувь нь хэвийн гарсан байна. Хөхний эрт илрүүлэг үзлэгт 21622 эмэгтэй хамрагдаж, хамрагдвал зохих насны эмэгтэйчүүдийн 88.4 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 10.2 хувиар буурсан байна.

Жирэмсний хяналт

Жирэмсний хяналтад шинээр 1582 жирэмсэн эмэгтэйчүүд хамрагдан эхний 3 сартайд 1566 буюу 99.0 хувь нь хяналтад орж, өмнөх оны мөн үеэс эрт үеийн хяналт 0.2 хувиар буурсан. Хяналтад орсон жирэмсэн эмэгтэйчүүдийн 99.8 хувь цусны шинжилгээнд хамрагдсанаас 47 буюу 3.0 хувь нь цус багадаалттай байна. Шинээр хяналтад хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүдийн БЗДХ-ын шинжилгээний үзүүлэлтэд трихомониаз 33 буюу 2.1 хувь, тэмбүү 11 буюу 0.7 хувь, заг хүйтэн 1 буюу 0.06 хувь тус тус эерэг гарсан байна.

Эрт үеийн жирэмсний хяналт



БЗДХ-ын шинжилгээний үзүүлэлт

| | | Трихомониаз эерэг | Заг хүйтэн эерэг | Тэмбүү эерэг |
|---------|----------------------|-------------------|------------------|--------------|
| 2024 он | Орхон аймаг | 32 | 3 | 9 |
| | Аймгуудын дүн | 270 | 49 | 255 |
| | Улсын дүн | 628 | 77 | 726 |
| 2025 он | Орхон аймаг | 33 | 1 | 11 |
| | Аймгуудын дүн | 200 | 28 | 210 |
| | Улсын дүн | 523 | 53 | 704 |

Үр хөндөлт

Аймгийн хэмжээнд 2025 онд нийт 287 эмэгтэйчүүд үр хөндөх мэс ажилбарыг хийлгэсэн ба өмнөх оны мөн үеэс 74 тохиолдлоор нэмэгдэж, нийт үр хөндөлтөд 20 хүртэлх насны үр хөндөлтийн тохиолдол 30 (10.5%), хожуу үр хөндөлт 10 (3.5%) эзэлж байна.

Үр хөндөлтийн түвшин

| | Үр хөндөлтийн тоо | | Үр хөндөлтийн харьцаа (1000 амьд төрөлтөд) | |
|----------------------|-------------------|-------------------|--|-------------------|
| | 2024 оны байдлаар | 2025 оны байдлаар | 2024 оны байдлаар | 2025 оны байдлаар |
| Орхон аймаг | 213 | 287 | 105.6 | 148.2 |
| Аймгуудын дүн | 3001 | 3028 | 114.0 | 123.8 |
| Улсын дүн | 12676 | 11797 | 219.5 | 217.9 |

Охидын жирэмслэлт, төрөлт, үр хөндөлт

| | Өсвөр насны охидын | | | |
|--------------------------|---------------------------|--------------------------|----------------------|--------------------------|
| | жирэмслэлтийн коэффициент | жирэмслэлтийн эзлэх хувь | төрөлтийн эзлэх хувь | үр хөндөлтийн эзлэх хувь |
| 2024 оны байдлаар | 6.3 | 3.3 | 3.3 | 5.6 |
| 2025 оны байдлаар | 6.2 | 3.7 | 4.0 | 3.5 |
| Өсөлт бууралт | -0.1 | +0.4 | +0.7 | -2.1 |

Түргэн тусламжийн дуудлага

14186 түргэн тусламжийн дуудлага хүлээн авч үйлчилсэнээс 1.6 хувийг алсын, 7.8 хувийг осол, гэмтлийн дуудлага эзэлж байна.

| | Түргэн тусламжийн дуудлага | | | Алсын дуудлагын эзлэх хувь | Осол, гэмтлийн дуудлагын эзлэх хувь |
|--------------------------|----------------------------|----------------|------------------------|----------------------------|-------------------------------------|
| | Нийт | Алсын дуудлага | Осол гэмтлийн дуудлага | | |
| 2024 оны байдлаар | 16451 | 293 | 2577 | 1.8 | 15.7 |
| 2025 оны байдлаар | 14186 | 213 | 1107 | 1.6 | 7.8 |
| Үзүүлэлт | -2265 | -80 | -1470 | -0.2 | -7.9 |

Хэвтэн эмчлүүлэгчдийн тусламж үйлчилгээ

2025 онд тайлан ирүүлсэн 156 эрүүл мэндийн байгууллагаас хүн амд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлж байгаа бүсийн оношилгоо эмчилгээний төв 1, өрхийн эрүүл мэндийн төв 8, сумын эрүүл мэндийн төв 1, ортой хувийн клиник 12, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг 1, хувийн клиник 56 байна. Аймгийн хэмжээнд 31177 үйлчлүүлэгч эмнэлэгт хэвтэн эмчлүүлж, 200316 ор хоног ашиглаж, ор ашиглалтын хувь 64.4, дундаж ор хоног 6.4 байна.

Эмнэлгийн тусламж үйлчилгээний зарим үзүүлэлтүүд

| | Орны тоо | Хэвтсэн өвчтөн | Эмчлэгдэж гарсан өвчтөн | Ор хоног | Эмнэлгийн нас баралт | Хоног болоогүй нас баралт | Хоног болоогүй нас баралтын хувь | Үүнээс | | Орны фонд ашиглалт | Фонд ашиглалтын хувь | Дундаж ор хоног | Орны эргэлт |
|--------------------|------------|----------------|-------------------------|---------------|----------------------|---------------------------|----------------------------------|------------------------------|-------------------------------------|--------------------|----------------------|-----------------|-------------|
| | | | | | | | | 8-24 цагийн дотор нас баралт | 8-24 цагийн дотор нас баралтын хувь | | | | |
| БОЭТ | 433 | 14920 | 14864 | 96194 | 143 | 43 | 30.1 | 21 | 48.8 | 222.2 | 67.3 | 6.5 | 34.3 |
| СЭМТ | 12 | 298 | 303 | 2115 | | | | | | 176.3 | 53.4 | 7.0 | 25.3 |
| ЭТ медикал | 38 | 1357 | 1385 | 4653 | | | | | | 122.4 | 37.1 | 3.4 | 36.4 |
| ХХЭМБ | 459 | 14541 | 14625 | 97354 | 1 | | | | | 212.1 | 64.3 | 6.7 | 31.9 |
| Аймгийн дүн | 942 | 31116 | 31177 | 200316 | 144 | 43 | 29.9 | 21 | 48.8 | 212.6 | 64.4 | 6.4 | 33.1 |

2025 оны байдлаар 10 000 хүн амд дунджаар 88.5 хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний ор ногдож байгаа нь өмнөх оны дунджаас 0.9-өөр буурсан байна.

Хэвтэн эмчлүүлэгчдийн өвчлөлийн тэргүүлэх шалтгаан 10 000 хүн амд


2025 оны байдлаар

| № | ӨОУА-10 нэршил | Тохиолдлын тоо | 10 000 хүн амд | Нийт тохиолдлын хувь |
|---|--|----------------|----------------|----------------------|
| 1 | Зүрх-судасны тогтолцооны өвчин | 4720 | 443.7 | 15.1 |
| 2 | Амьсгалын тогтолцооны өвчин | 4347 | 408.6 | 13.9 |
| 3 | Хоол боловсруулах тогтолцооны өвчин | 3709 | 348.6 | 11.9 |
| 4 | Яс булчингийн тогтолцоо ба холбох эдийн өвчин | 2366 | 222.3 | 7.6 |
| 5 | Шээс бэлгийн тогтолцооны өвчин | 1778 | 167.1 | 5.7 |
| 6 | Мэдрэлийн тогтолцооны өвчин | 1654 | 155.5 | 5.3 |
| 7 | Гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэг | 1265 | 118.9 | 4.1 |
| 8 | Сэтгэцийн ба аягийн эмгэг | 1207 | 113.5 | 3.9 |


Халдварт бус өвчлөл

Аймгийн хэмжээнд 2025 оны байдлаар 10 000 хүн амд ногдох амбулаторийн өвчлөл (60988)-ийн түвшин 5732.7 болж, өмнөх оноос 455.3-аар буурсан байна.

Хүн амын өвчлөлийн тохиолдол 1000 хүн амд



Бүртгэгдсэн нийт өвчлөл 10 000 хүн амд, хүйсээр



Амбулаторийн өвчлөлийн тэргүүлэх шалтгаан 10 000 хүн амд

2025 оны байдлаар

| № | ӨОУА-10 нэршил | Тохиолдлын тоо | 10 000 хүн амд | Нийт тохиолдлын хувь |
|----|--|----------------|----------------|----------------------|
| 1 | Амьсгалын тогтолцооны өвчин | 14783 | 1389.5 | 24.2 |
| 2 | Хоол боловсруулах тогтолцооны өвчин | 11146 | 1047.7 | 18.3 |
| 3 | Шээс бэлгийн тогтолцооны өвчин | 9480 | 891.1 | 15.5 |
| 4 | Зүрх-судасны тогтолцооны өвчин | 5658 | 531.8 | 9.3 |
| 5 | Нүд ба түүний дайврын өвчнүүд | 4416 | 415.1 | 7.2 |
| 6 | Арьс ба халимны өвчин | 4453 | 418.6 | 7.3 |
| 7 | Яс булчингийн тогтолцоо ба холбох эдийн өвчин | 3401 | 319.7 | 5.6 |
| 8 | Мэдрэлийн тогтолцооны өвчин | 2015 | 189.4 | 3.3 |
| 9 | Дотоод шүүрхэл,тэжээлийн ба бодисын солилцооны өвчнүүд | 1643 | 154.4 | 2.7 |
| 10 | Гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэг | 970 | 91.1 | 1.6 |

Хүн амын өвчлөлийн тэргүүлэх шалтгаан

Амьсгалын тогтолцооны өвчлөлд:

- Цочмог бронхит 4085 буюу 27.6%
- Цочмог гүйлтэс,тонзиллит 2091 буюу 14.1%
- Амьсгалын дээд замын бусад цочмог халдвар 1683 буюу 11.4%
- Хамрын ба хамрын хамрын ангалын бусад эмгэг 1539 буюу 10.4%
- Уушгины хатгаа 1469 буюу 9.9%

Хоол боловсруулах тогтолцооны өвчлөлд:

- Шүд ба дайвар бүтцийн бусад эмгэг 2086 буюу 18.7%
- Шүд цоорох,кариес 1690 буюу 15.2%
- Ходоод ба дээд гэдэс,гастрит ба доуденит 1189 буюу 10.7%
- Цочмог нойр булчирхайн бусад өвчнүүд 1215 буюу 10.9%
- Цэсний замын өвчнүүд 955 буюу 8.6%


Шээс бэлгийн тогтолцооны өвчинд:

- Шээс ялгаруулах тогтолцооны бусад эмгэг 2441 буюу 25.7%
- Үтрээний үрэвсэл 2027 буюу 21.4%
- Бөөрний архаг үрэвсэл 1774 буюу 18.7%
- Цэвэрших үеийн бусад эмгэгүүд 533 буюу 5.6%
- Хөхний эмгэгүүд 308 буюу 3.2% тус тус эзэлж байна.

Хорт хавдрын тэргүүлэх шалтгаан

2025 оны байдлаар 294 хорт хавдрын шинэ өвчлөл оношлогдсоны 115 (39.1%) эрэгтэй, 179 (60.9%) эмэгтэй.Элэгний хорт хавдраар 82 тохиолдол шинээр оношлогдсоны 42.7 хувь эрэгтэй, 57.3 хувь нь эмэгтэйчүүд байгаа нь нийт хорт хавдрын 27.9 хувийг эзэлж байна.

Хорт хавдрын өвчлөлийн бүтэц



Гурав.Хүн амын нас баралт

2025 оны байдлаар аймгийн хэмжээнд нас баралтын 496 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 29 тохиолдлоор буурч нийт нас баралтын 29.0 хувь нь эмнэлэгт нас барсан бөгөөд үүнээс 43 тохиолдол буюу 29.9 хувийг хоног болоогүй нас баралт эзэлж, эмнэлэгт хоног болоогүй нас баралт өмнөх оны мөн үеэс 1 тохиолдлоор буурсан байна.



Нас баралтын түвшин 1000 хүн амд 4.7 байна. Нас баралтын 3.2 хувийг тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл эзэлж, осол гэмтэл, гадны шалтгаант нас баралтын 51 тохиолдол бүртгэгдэж, нийт нас баралтын 10.3 хувийг эзэлж өнгөрсөн оны мөн үеэс 17 тохиолдлоор өссөн бөгөөд 10 000 хүн амд ногдох осол гэмтэл, гадны шалтгаант нас баралт 4.8 байна.

Осол гэмтлийн нас баралтын шалтгаан:

| | Бүгд | Амиа хорлолт | Бусад хорлогдсон | Зам тээврийн осол | Бусад осол | Тодорхойгүй |
|--------------------------|-----------|--------------|------------------|-------------------|------------|-------------|
| 2024 оны байдлаар | 34 | 3 | 3 | 2 | 26 | |
| 2025 оны байдлаар | 51 | 2 | 1 | 9 | 38 | 1 |

Нас баралтын тэргүүлэх 5 шалтгаан 10 000 хүн амд

| | Зүрх судасны тогтолцооны өвчин | Хавдар | Гэмтэл хордлого, гадны шалтгаан | Хоол боловсруулах тогтолцооны өвчин | Дотоод шүүрэл,тэжээлийн ба бодисын солилцооны өвчин |
|--------------------------|--------------------------------|-------------|---------------------------------|-------------------------------------|---|
| 2024 оны байдлаар | 17.6 | 15.6 | 3.2 | 3.5 | 1.4 |
| 2025 оны байдлаар | 15.9 | 14.1 | 4.8 | 3.1 | 1.4 |

Нас баралтын нэгдүгээр шалтгаан болох зүрх судасны тогтолцооны өвчин дотор:


| 2024 оны байдлаар 185 |
|--|
| • Бусад зүрх судасны тогтолцооны өвчин 79 буюу 42.7% |
| • Зүрхний ишеми 52 буюу 28.1% |
| • Зүрхний шигдээс 21 буюу 11.4% |
| •Тархины цус харвалт 14 буюу 7.6% |

| 2025 оны байдлаар 169 |
|--|
| • Бусад зүрх судасны тогтолцооны өвчин 74 буюу 43.8% |
| • Зүрхний ишеми 32 буюу 18.9% |
| • Зүрхний шигдээс 31 буюу 18.3% |
| • Тархины цус харвалт 11 буюу 6.5% |

Хорт хавдрын шалтгаант нас баралт

Хавдраас шалтгаалсан нас баралт 2024 оны мөн үеэс 14 тохиолдлоор буурсан хэдий ч нас баралтын 2 дахь шалтгаан болсоор байгаа бөгөөд нас барагчдыг хүйсээр нь үзэхэд 61.1 хувь нь эрэгтэйчүүд байгаа нь эмэгтэйчүүдээс илүү өвчилж,нас барж байна. 2025 оны байдлаар хорт хавдрын шалтгаант нас баралт нийт нас баралтын 30.2 хувийг эзэлж, нас баралтын түвшин 10 000 эрэгтэй хүн амд 17.4 10 000 эмэгтэй хүн амд 10.7 ногдож, хавдрын төрлийн дийлэнх нь элэг, ходоод, умай хүзүү,уушгины хорт хавдраас болж нас барж байна.

Элэгний хорт хавдрын нас баралт,10 000 хүн амд,хүйсээр



Элэгний хорт хавдар нь хүн амын нас баралтыг өвчлөлөөр тооцоход эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн нас баралтын 1-р шалтгаан болсоор байгаа бөгөөд өнгөрсөн онтой харьцуулахад 6 тохиолдлоор буурсан байна.

Эмгэг судлалын шинжилгээ

2025 онд эмнэлгийн нас баралтын 144 тохиолдол бүртгэгдсэнээс 46.8 хувьд нь эмгэг судлалын болон шүүх эмнэлгийн задлан шинжилгээ хийгдсэн байна.

Эмгэг судлалын шинжилгээний үзүүлэлт

| | Эдийн шинжилгээ | Эсийн шинжилгээ | Эмнэлэгт бүртгэгдсэн нас баралт | Хийгдсэн задлан шинжилгээ | | Амьгүй төрөлт | Амьгүй төрөлтөд хийгдсэн задлан шгээ | Задлан шинжилгээ хийгээгүй | Задлан шинжилгээний хувь | Оношийн зөрүү тоо | Оношийн зөрүүний хувь |
|--------------------------|-----------------|-----------------|---------------------------------|---------------------------|----------------|---------------|--------------------------------------|----------------------------|--------------------------|-------------------|-----------------------|
| | | | | Эмгэг судлалын | Шүүх эмнэлгийн | | | | | | |
| 2024 оны байдлаар | 1818 | 3236 | 125 | 63 | 10 | 8 | 1 | 52 | 55.6 | 7 | 10.9 |
| 2025 оны байдлаар | 2395 | 2508 | 143 | 57 | 13 | 9 | 2 | 73 | 47.4 | 3 | 6.1 |

Дөрөв.Халдварт өвчин

Аймгийн хэмжээнд 971 халдварт өвчний тохиолдол бүртгэгдэж, 10 000 хүн амд **91.3** ногдож, өмнөх оны мөн үеэс 202 тохиолдлоор нэмэгдсэн байна. 2025 оны байдлаар халдварт өвчний бүтцийг харахад нийт халдварт өвчний 40.8 хувийг амьсгалын замын халдвар эзэлж байгаагийн (47.5 нь салхинцэцэг, 20.2 хувийг сүрьеэ, 14.4 хувийг улаанбурхан, 10.4 хувийг гар хөл амны өвчин 7.6 хувийг гахай хавдар,) 35.1 хувийг мөөгөнцөр, 18.7 хувийг бэлгийн замаар дамжих халдвар, 3.8 хувийг гэдэсний халдвар, 0.4 хувийг цусаар дамжих халдвар,0.3 хувийг зоонозын халдварт өвчин тус тус эзэлж байна. Бэлгийн замаар дамжих халдварт өвчний 42.3 хувийг трихомониаз, 40.7 хувийг тэмбүү, 16.5 хувийг заг хүйтэн тус тус эзэлж, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад тэмбүүгийн өвчлөл 22 тохиолдол буюу 10 000 хүн амд 2.1 промиллоор нэмэгдэж, төрөлхийн тэмбүү 2 бүртгэгдсэн байна.

Нийт халдварт өвчин 10 000 хүн амд

| | | 2024 оны байдлаар | 2025 оны байдлаар |
|-------------|-----------------------|-------------------|-------------------|
| Орхон аймаг | Нийт халдварт өвчин | 769 | 971 |
| | 10 000 хүн амд | 73.1 | 91.3 |
| Улсын дүн | Нийт халдварт өвчин | 37312 | 52882 |
| | 10 000 хүн амд | 106.5 | 149.2 |

Халдварт өвчний тохиолдол, нас баралт, төрлөөр

2025 оны байдлаар

| № | Халдварт өвчин төрөл | Өвчлөл | | | | Нас баралт | | | |
|----------------------------|--------------------------------------|------------|----------------|------------|----------------|------------|----------------|----------|----------------|
| | | 2024 | | 2025 | | 2024 | | 2025 | |
| | | Тоо | 10 000 хүн амд | Тоо | 10 000 хүн амд | Тоо | 10 000 хүн амд | Тоо | 10 000 хүн амд |
| 1 | Амьсгалын замын халдварт өвчин | 277 | 26.3 | 396 | 37.6 | 5 | 0.5 | 2 | 0.2 |
| 2 | Бэлгийн замаар дамжих халдварт өвчин | 151 | 14.3 | 182 | 17.1 | | | 1 | 0.09 |
| 3 | Гэдэсний халдварт өвчин | 63 | 6.0 | 37 | 3.5 | | | | |
| 4 | Зоонозын халдварт өвчин | 1 | 0.09 | 3 | 0.3 | 1 | 0.09 | | |
| 5 | Цусаар дамжих халдварт өвчин | 4 | 0.4 | 4 | 0.4 | | | | |
| 6 | Бусад халдварт өвчин | 273 | 25.9 | 349 | 32.8 | | | | |
| Нийт халдварт өвчин | | 769 | 73.1 | 971 | 91.3 | 6 | 0.6 | 3 | 0.3 |

Амьсгалын замын халдварт өвчин

2025 оны байдлаар аймгийн хэмжээнд амьсгалын замын халдварт өвчний 396 тохиолдол бүртгэгдэж, нийт халдварт өвчний 40.8 хувийг эзэлж, амьсгалын замын халдварт өвчин өмнөх оноос 119 тохиолдлоор нэмэгдсэн байна.

Амьсгалын замын халдварт өвчний тохиолдол

